

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/294 тоот “Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралт “Эмгэг судлалын үндэсний төв”-ийн дүрмээр “1.1. Эмгэг судлалын үндэсний төв нь (цаашид Төв гэх) улсын хэмжээнд эмгэг судлалын үндсэн мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх бүхий тусгай мэргэшлийн төв мөн” “1.2. Төв нь эмгэг эд, эс, бүтцэд судлал, онош зүй, лабораторийн шинжилгээний аргуудад тулгуурлан эмгэг судлалыг онош тавих, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлгийн эмч нарын оношлогоо, эмчилгээ, үйлчилгэлийн чанарыг дээшлүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэшин, арга зүйнээр хангах, байгууллагын хөгжлийн хэтийн төлөв, бодлого боловсруулах зорилго бүхий эрүүл мэндийн байгууллага мөн” хэмээн чиг үүргийг тусгайлан зохицуулж өгсөн.

Хүснэгт 1. Эмгэг судлалын үндэсний төвийн чиг үүрэг

<i>Ерөнхий чиг үүрэг-1: Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн судалгаа</i>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Анатомийн эмгэг судлалын оношилгоо	Амьд сорьцын шинжилгээг хийж онош, дүгнэлт гаргах	ЭМЯ, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, Харилцагч эрүүл мэндийн байгууллага, үйлчлүүлэгч
	Эсийн эмгэг судлалын шинжилгээг хийж онош, дүгнэлт гаргах	
	Эмнэлгийн нас баралтад эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, онош, дүгнэлт гаргах	
2. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үйл ажиллагаа	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн эсийн эмгэг судлалын шинжилгээ хийж онош, дүгнэлт өгөх	ЭМЯ, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, Харилцагч эрүүл мэндийн байгууллага, үйлчлүүлэгч
	Эсийн эмгэг судлаач эмч, эс судлалын лабораторийн техникч нарыг мэргэжил арга зүйгээр хангах	

<p>3. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний хяналт, шинжилгээ, үнэлгээ</p>	<p>Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ үзүүлж буй нэгжид чанарын хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж мэргэжил, арга зүйгээр хангах</p>	<p>ЭМЯ, ЭСҮТ, Эмгэг судлаач эмч</p>
<p>Эх, хүүхдийн эндэгдлийн магадлан хэлэлцэх хуралд оролцож, шийдвэр гаргалтад оролцох</p>		
<p>4. Сургалт-эрдэм шинжилгээ-Инновац</p>	<p>Үндэсний хэмжээнд анатомийн эмгэг судлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх</p> <p>Рекидент</p> <p>Мэдрэлийн эмгэг судлал</p>	<p>ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС, сүлжээ СЭБ</p>
<p>Тандалт судалгааны тогтолцоог бий болгох</p>		
<p>Анагаах ухааны шинэ технологи, арга аргачлал нэвтрүүлэх</p>		
<p>5. Байгууллагын бодлого боловсруулах, хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох</p>	<p>Байгууллагын стратеги, бодлого, дотоод журам боловсруулах, хэрэгжүүлэх</p>	<p>ЭМЯ, Бодлого боловсруулагч байгууллагууд, ЭСҮТ</p>

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА